



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 07 сарын 26 өдөр

Дугаар А/261

Мандалговь

Монгол Улсын Төрийн дээд шагнал  
хүртсэн А.Амбасэлмааг шагнаж  
урамшуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.17, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 05 дугаар сарын 12-ний өдрийн 90 дүгээр зарлиг, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.6, аймгийн Засаг даргын 2017 оны А/251 дүгээр захирамжаар батлагдсан “Урамшууллын жишиг тогтоох журам”-ын 2.2 дахь заалт, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2021 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн 10 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

- 1.Дэрэн сумын уугуул, эрүүл ахуйч их эмч Амаржаргал овогтой Амбасэлмаа нь “Эрүүлийг хамгаалахын Гавьяат ажилтан” цол хүртсэн тул аймгийн Засаг даргын “Хүндэт өргөмжлөл”, мөнгөн шагналаар шагнасугай.
- 2.Шагналын зардлыг хавсралтаар баталсугай.
- 3.Дээрх шагналд шаардагдах нийт 493500 (дөрвөн зуун ерэн гурван мянга таван зуу) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Л.Доржбат), нягтлан бодогч (М.Янжиндолгор) нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА Ц.МӨНХБАТ



481210901